

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2025/056/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2025 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Алтанцэцэг Утас: 8000-7121 Цахим хаяг: tolinetugen@gmail.com Толин этүгэн аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Б.Отгон-Өлзий Утас: 99844655 Цахим хаяг: otgon1118@yahoo.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25 № 09
танай _____ -ны № _____ -т

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 7 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.БАЯНМӨНХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өмнөговь аймгийн хэмжээнд хэрэгжиж буй үдийн цай хөтөлбөрт зургаадугаар ангийн сурагчдыг хамруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хандив тусламжаар 2,100.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,400.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 7 зорилт, 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 92.6 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл\Docx
4625020215

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Даланзадгад сумын спортын долоодугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/мянган төгрөгөөр/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31	
Санхүүгийн байдлын тайлан			
Эргэлтийн хөрөнгийн дүн	85,820.9	319,489.3	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,373,615.2	3,510,421.6	
Нийт хөрөнгийн дүн	3,459,436.1	3,829,910.9	
Нийт өр төлбөрийн дүн	-	-	
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,459,436.1	3,829,910.9	
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,459,436.1	3,829,910.9	
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
Үйл ажиллагааны орлогын дүн	1,884,867.3	2,475,814.6	
Үйл ажиллагааны зардлын дүн	1,629,855.0	2,104,931.4	
Үйл ажиллагааны үр дүн	255,012.3	370,883.2	
Үйл ажиллагааны бус үр дүн	(3,038.3)	(408.4)	
Үйл ажиллагааны нийт үр дүн	251,974.0	370,474.8	
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,207,462.1	3,459,436.1	
Тайлант оны үр дүн	251,974.0	370,474.8	
Эцсийн үлдэгдэл	3,459,436.1	3,829,910.9	
Мөнгөн гүйлгээний тайлан			
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,498,559.1	2,106,887.6	
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,457,128.7	1,887,783.0	
Үйл ажиллагааны ЦМГ	41,430.4	219,104.5	
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(22,972.6)	(54,946.0)	
Санхүүгийн ажиллагааны ЦМГ			
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	18,457.8	164,158.5	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,778.5	36,236.2	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	36,236.2	200,394.7	
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,185,608.1	1,941,639.1	
Урсгал зардал	2,185,608.1	1,941,639.1	
Хөрөнгийн зардал			
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,204,065.8	2,105,797.6	
Улсын төсвөөс санхүүжих	2,070,608.5	1,590,561.9	
Орон нутгийн төсвөөс	133,457.4	132,367.5	
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос			

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,000,0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Илрүүлэлт: 1 Сургуулийн судалгаа хөгжлийн шинэ монгол төв НҮТББ -тай ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах үйл ажиллагааг хамтран 2024.09.15-2025.06.30-ны хооронд багш нарт модуль сургалтыг 1 жил буюу 32 долоо хоногийн турш зохион байгуулахаар 10,000.0 төгрөгийн гэрээг байгуулж, төлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 26-нд шилжүүлж гэрээний дүнгээр урьдчилж төлсөн тооцоо дансаар бүртгээгүй шууд зардалд бичсэн байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйл, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: НББ-ийн стандартын дагуу бүртгэлийг хөтлөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хяналтын байгууллагад шилжүүлсэн		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Сургуулийн судалгаа хөгжлийн шинэ монгол төв НҮТББ -тай ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах үйл ажиллагааг хамтран 2024.09.15-2025.06.30-ны хооронд багш нарт модуль сургалтыг 1 жил буюу 32 долоо хоногийн турш зохион байгуулахаар 10,000.0 төгрөгийн гэрээг байгуулж, төлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 26-нд шилжүүлж гэрээний дүнгээр урьдчилж төлсөн тооцоо дансаар бүртгээгүй шууд зардалд бичсэн байна.	1	10,000.0						1	10,000.0		
Нийт	1	10,000.0						1	10,000.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 1,033,150.0 мянган төгрөгийн 16 санхүүжилтийн орлогын гүйлгээг мэдээлээгүй байна.								1 0
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								